

МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 11 өдөр

Дугаар 8/298

Номгон

Уул уурхайн аж ахуйн нэгжүүдийн  
гэрээний хэрэгжилтийг дүгнэж, хяналт  
шалгалт хийх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3."н", Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.4, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээнд уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, холбогдох бичиг баримтын дагуу үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд хяналт, шалгалт хийж, 2020 онд байгуулсан "Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай" гэрээний хэрэгжилтийг дүгнэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, ажлын удирдамжийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Ажлын хэсгийн бүрэлдэхүүн хяналт шалгалт хийхэд шаардагдах зардлыг шийдвэрлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Энхжаргал)-д даалгасугай.


3.Уул уурхайн аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж, гэрээний хэрэгжилтийг дүгнэх ажлыг чанартай гүйцэтгэж 2021 оны 06 дугаар сарын 30-ны дотор Засаг даргын зөвлөлд танилцуулж ажиллахыг ажлын хэсэг (Г.Энхбаяр)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

Аймгийн Засаг даргын 2021 оны 05 дугаар  
сарын 11-ний өдрийн А/296 дугаар  
захирамжийн 1 дүгээр хавсралт



**УУЛ УУРХАЙН АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН  
ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ДҮГНЭЖ, ХЯНАЛТ  
ШАЛГАЛТ ХИЙХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч: Г.Энхбаяр –Байгаль орчин, уул уурхай, нийгмийн бодлогын асуудал хариуцсан орлогч дарга

Гишүүд: Т.Хишигбаатар –Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Н.Бямбадорж –Мэргэжлийн хяналтын газрын дарга

М.Магвансүрэн – Мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчин, дэд бүтэц, хөдөлмөрийн хяналтын хэлтсийн дарга, улсын ахлах байцаагч

Ц.Болорчимэг -Мэргэжлийн хяналтын газрын Геологи уул уурхайн хяналтын Улсын байцаагч

Б.Дарханбаяр -Мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчны хяналтын Улсын байцаагч

Нарийн бичиг: Б.Намуун –Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

оОо

Аймгийн Засаг даргын 2021 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн А/298 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



**УУЛ УУРХАЙН АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН  
ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ДҮГНЭЖ, ХЯНАЛТ  
ШАЛГАЛТ ХИЙХ АЖЛЫН УДИРДАМЖ**

**Зорилго:** Уул уурхайн аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаагаа эхлэх баримт бичгийн бүрдэл, хуулийн дагуу үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд хяналт, шалгалт хийж, 2020 онд байгуулсан “Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай” гэрээний хэрэгжилтийг дүгнэх

**Зорилт:** Уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг ашиглах талаар хууль тогтоомжид заасан үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих, гэрээ дүгнэх

**Хугацаа:** 2021 оны 05 дугаар сарын 12-ны өдрөөс 2021 оны 06 дугаар сарын 15

**Хамрах хүрээ:** 6 сумын 15 аж ахуйн нэгж, байгууллага

№	Сумын нэр	Аж ахуйн нэгжийн нэр
1	Баян-Овоо	Наранмандал Энтерпрайзес ХХК
2	Галуут	Ар Эс И ХХК
3		Имperiал гоулд майнинг ХХК
4		Шижир Аранжин ХХК
5		Монголболгаргео ХХК
6		Өлзийт
7	Гурванбулаг	Жи энд юу голд ХХК
8		Жи эс би ресурс ХХК
9	Бөмбөгөр	Эрдэнэ цагаач ХХК
10		Вояжер минерал ресурс ХХК
11		Эл Ти Ди ХХК
12		Ай Эн Ди ХХК
13		Тулгат нутаг ХХК
14	Стар холдинг ХХК	
15	Шинэжинст	Бритиш майнинг ХХК